

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ " ЖОНШТ ТОЛГОЙН" ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ" ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гарчиг

Оршил.....	3
.....	3
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	4
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	8
Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	8

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө.....	10
Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	10
Химийн бодис эрсдлийн менежментийн төлөвлөгөө	11
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	13
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	16

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛӨЛД

Өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	17
Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (охшх).....	18

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ОРШИЛ

Манай компани нь Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт MV-6506 бүхий тусгай зөвшөөрөлтэй 203 га талбайд “Жоншт Толгой” нэртэй орд газар уурхайн олборлолт, мөн Гүн Галуутайн 2-р багийн нутаг дэвсгэрт жонш боловсруулах үйлдвэрийн үйлажиллагааг тус тус эрхлэн явуулдаг.

Энэхүү цар тахал нөмөрсөн хүнд хэцүүүед бизнес болоод компанийн үйл ажиллагааг тогтвортой авч явах үүднээс жил бүр ашиглалт олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэн ажиллана гэсэн төлөвлөгөөтэйгөөр чармайн ажиллаж байна.

Гэвч, 2019 оноос өнөөдрийг хүртэл уурхайн олборлолт, үйлдвэрийн ашиглалтын ажил огт хийгдээгүй боловч, 2020онд орд ашиглах ТЭЗҮ болон БОННУ-нд тодотгол оруулж түүнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үүргийн дагуу жил бүр уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэргийг цаг тухай бүрд нь боловсруулан, ажилладаг.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2024 ОН

Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөгөнд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.

Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.

Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.

Аймаг, Сум, орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг тухайн жилийн хугацаанд буюу 2024 оны хугацаанд төлөвлөв.

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дэвсгэрт “Чулуут интернэшнл” ХХК-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Жоншт толгой” хайлуур жоншны орд ашиглах төслөөс байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

ТӨСЛИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
АГААРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Тээврийн хэрэгслийн үүсгэх тоосжилт Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох Хүдэр, хаягдал чулуу тээвэрлэх, ачих, буулгах үед үүсэх тоосжилт	Уурхайн дотоод тээврийн замыг сайжруулж бэлтгэх	2024	2км	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан		Уурхайн дарга	Сайжруулсан замаар тээвэр хийхэд тоосжилт багассан байна.	MNS 4585:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS(ISO)13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Хамгаалалтын хувцас- Ерөнхий шаардлага MNS5620:2006 Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл. (Хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг)
	Хурдны хязгаар тогтоох	Байнга	2км			ХАБ-ын ажилтан	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт буурсан байх	
	Тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг тоосжилт дарах бодистой усаар усалж байх	Байнга	23.79га	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	БО-ны ажилтан	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт буурсан байх		
Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх,	Ажиллагсад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, сургалт	2024	15 ажилчид	Хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан		ХАБ-ын ажилтан	Ажиллагсдын дунд өвчлөл буурч, хөдөлмөр хамгааллын хувцасны хангамж сайжирснаар	

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	сурталчилгаа явуулах							MNS5623:2006 Хөлний хамгаалалт Ажлын тусгай гутал MNS5388:2004 Толгой хамгаалах хэрэгсэлсонсголын эрхтэн хамгаалах хэрэгсэл (бөглөө. чихэвч)-техникийн ерөнхий шаардлага
	Баяжуулах үйлдвэрийн ажлын байранд тоос сорох камер суурилуулах	2024	1ш			БО-ны ажилтан	Ажлын байрны нөхцөл сайжрах	
Агаарын чанрын хяналт	Нөлөөллийн бүс	Жилд 2 удаа	2 цэг	ОХШХ тусгагдсан		Итгэмжлэгдсэн лаборатори	Хэмжилтийн үр дүнгийн дагуу	
ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Шимт хөрсний үе давхаргыг хуулах, ачих, хадгалах тээвэрлэх.	Нийт эвдэгдэх талбай 12.5 га	2024	7.2 га	Нөхөн сэргээлтийн зардалд багтсан	БО-ны ажилтан	Шимт хөрсийг 0.2м-ээр хуулж, эцсийн хүрээнээс урагш 40-60 м-ийн зайд 2м-ийн өндөрт хураасан байна..		MNS5916:2008 Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт
Уурхайн орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээтэй болж, тэмдэг тэмдэглэгээг хийх, сайжруулах	Уурхай болон үйлдвэрийн хэмжээнд	Тухай бүрд	10 ш	Үйл ажилгааны зардалд хамаарна	Уурхайн дарга, Үйлдвэрийн дарга БО-ны ажилтан	Сайжруулсан тогтсон маршруттай замтай болсон байх		Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай болон бусад холбогдох эрхзүй Монгол Улсын “Газрын тухай хууль”-ийн 2002 оны шинэчилсэн найруулгын 6 дугаар бүлгийн 58 дугаар зүйл Засгийн Газрын
Хөрсийг элдэв бохирдлоос хамгаалах /авто засвар, түлш олгох, тос масло хадгалах хэсгийг хатуу хучилттай болгох/	Түлш олгох хэсэг болон засварын газар	2024	1.2 га		БО-ны ажилтан	Уурхайн эзэмшил газрын хэмжээнд асгаралт, бохирдол үүсээгүй байх		

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрсний үршил шим, бохирдлын үзүүлэлтүүдийг хянаж шинжлэх	Тогтоосон цэгт	Жилд 2 удаа	2 цэгт	ОХШХ-т тусгагдсан	БО-ны ажилтан Итгэмжлэгдсэн лаборатори	Шинжилгээний үр дүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээг төлөвлөж ажиллах	2003 оны 28 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2013 оны А/174-р тушаалаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх түр журам” Засгийн газрын 2018 оны 379 тогтоол, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу	
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа	Уурхай болон баяжуулах үйлдвэрийн эзэмшил газарт	5 жил тутамд	Талбайд	Санхүүгийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах	Мэргэжлийн байгууллагаар Компанийн удирдлага	Газрын төлөв байдал, хянан баталгааны дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх		
Баяжмал тээвэрлэлтийн замыг хатуу хучилттай болгох	Уурхайн дотоод, гадаад зам	2024	14 км	Санхүүгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	Компаний удирдлага Мэргэжлийн байгууллагаар	Хатуу хучилттай замаар тээвэр хийхэд тоосжилт багассан байна		
УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Ашиглалтгүй талбайн ургамлыг талхлагдлаас хамгаалах	Уурхайн хэмжээнд		-	-	Үйл ажиллагааны зардал	БО-ны ажилтан	Хайс хамгаалалт, тэмдэгжүүлэлт хийгдэж, хамгаалагдсан байна	-

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн тосгоны тохижилт, нөхөн сэргээлтийн туршилтын талбай байгуулах	2 га	Байнга	-	-	Нөхөн сэргээлтийн зардалд	БО-ны ажилтан	Ашиглалтын эхний жилээс эхлэн хэрэгжүүлснээр нөхөн сэргээлтэд хэрэглэх үр, тарьцын талаар туршлага, нөөц хуримтлуулсан байна.	-
Нутгийн ургамлын үр түүх, биологийн нөхөн сэргээлтийн туршилт	Туршилтын талбайд		-	-				-
УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Ашиглалтгүй талбайн ургамлыг талхлагдлаас хамгаалах	Уурхайн хэмжээнд	-	-	Үйл ажиллагааны зардлаас	БО-ны ажилтан		Хайс хамгаалалт, тэмдэгжүүлэлт хийгдэж, хамгаалагдсан байна.	
Уурхайн тосгоны тохижилт, нөхөн сэргээлтийн туршилтын талбай байгуулах	2 га	Байнга	-	Нөхөн сэргээлтийн зардалд	БО-ны ажилтан		Ашиглалтын эхний жилээс эхлэн хэрэгжүүлснээр нөхөн сэргээлтэд хэрэглэх үр, тарьцын талаар туршлага, нөөц хуримтлуулсан байна	
Нутгийн ургамлын үр түүх, биологийн нөхөн сэргээлтийн туршилт	Туршилтын талбайд	Байнга	-	Нөхөн сэргээлтийн зардалд	БО-ны ажилтан			
УСНЫ ЧАНАР, НӨӨЦӨД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Гүний худаг гаргах зөвшөөрөл авч хуулийн дагуу ус ашиглах	Төслийн ойр орчим	2024	2	Хөрөнгө оруулалтын зардалд тусгагдсан	Мэргэжлийн байгууллагаар	Ус ашигласан төлбөр тооцоог орон нутагт төлөх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль MNS	

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	Ашиглах худгаас	2024	1	250.000	БО-ны ажилтан			4288:1995 Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага /ЗГ-ын 2013 оны 327 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
Хөрс хамгаалах, хөрсний бохирдлоос сэргийлэх ажлыг хэрэгжүүлсэн байх	Ашиглалтын бүх талбайд	Байнга	-	Бусад зардалтай уялдана	Уурхайн дарга	Хөрсний бохирдолгүй бол хөрсөөр дамжин газрын доорх ус бохирдохгүй		
Ахуйн бохир ус цэвэршүүлэх байгууламжийг байгуулж, хаягдал усыг ашиглах	Баяжуулах үйлдвэрийн талбайд	2024	1	3.500.000	Компанийн удирдлага	Усны нөөц хэмнэх, хаягдал ус ашиглах		
Уурхай болон үйлдвэрийн ойролцоох худгуудад мониторинг хийх	Ойр орчимд	Жил бүр	3	ОХШХ-ийн зардалд тусгасан	БО-ны ажилтан	Шинжилгээний дүнгээр		
АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ								
Мал, амьтан уурхайд унаж эрсдэхээс хамгаалж хашаа хамгаалалт хийх	Шаардлагатай хэсгүүдэд	2024	-	Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлаас	Компанийн удирдлага	Хамгаалалт хийгдсэн байна.		-
Уурхайн дотоод журманд ан, амьтдыг үргээж, цочоохгүй агнахгүй байх заалт оруулж мөрдүүлэх	-	Байнга	-	Үйлдвэрлэлийн зардлаар	БО-ны ажилтан	Дотоод журманд тодорхой заалт оруулсан байна		-
Нийт зардал				3.500.000				

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын уул-геологийн нөхцөл, ордыг ашиглах технологи зэргээс хамааран өмнөх ашиглалтын жилүүдэд гадаад овоолгоор хөрсийг шийдэж ирсэн. Төсөлд ашиглалтын 2 дахь жилээс эхлэн хөрсний овоолгыг хүдэр олборлолтын ажилтай зэрэгцүүлэн жил бүр дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, өрнөлгүй болсон хэсгүүдэд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж хүн болон техник, мал амьтан явахад саадгүй болгоно. Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажил нь дотоод овоолгыг түрж тэгшлэх явцад хийгдэх учир уурхайн гадна хураасан үржил шимт хөрсний овоолгоос хөрсийг тээвэрлэн шилжүүлж өрнөлтгүй болсон дотоод овоолго дээр хураасан үржил шимт хөрстэй хамт 0.2 метрийн зузаантайгаар үндсэн хөрсний овоолгын гадаргууг хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлдэнэ. Мөн ургамлын үр цацаж суулгах замаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төсөлд тусгав. Уул-техникийн нөхөн сэргээлт: Хөрсний овоолгыг тэгшлэх, хэлбэржүүлэх, хажууг налуулах болон шимт хөрсөөр бүрэх, суваг шуудуу татах зэрэг ажлууд болно. Биологийн нөхөн сэргээлт: Уул-техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан газрыг ургамалжуулах ажлыг эхлүүлэх, хөрсийг бордох, сайжруулах, арчлан тордох талаар тусгагдсан ажлууд хийгдэнэ. Уурхайн овоолгыг нөхөн сэргээхдээ өөрийн болон бусад орны туршлагад тулгуурлан тус уурхайн эдэлбэр газрын нөхцөлд тохирсон ургамлын төрөл зүйлийг дээр дурдсанаар туршилтын журмаар бий болгох нь цаашдын биологийн нөхөн сэргээлтийн ажилд ашиг тустай болох юм. Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардлыг төсөл хааж нөхөн сэргээлт эхлэх хүртэл жил бүр хөрөнгө мөнгө төсөвлөн, хуримтлуулж, нөхөн сэргээлтийн ажлын хуримтлал үүсгэх нь нөхөн сэргээлтийн ажлын цаг тухайд нь эхэлж үр дүнтэй явуулхад ач холбогдолтой юм. Иймд 2024 онд техникийн нөхөн сэргээлтийг 3.000.000 сая төгрөгөөр хийж гүйцэтгэнэ гэж төлөвлөв.

ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул, төслийн нөлөөлөлд өртсөн ба Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутгийн байршлыг сонгох, биологийн олон янз байлдлын суурь судалгаа хийх биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээг тогтоох, мониторинг хийх хөтөлбөр зохиох, төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах гэсэн үндсэн шат дараалалтайгаар дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулав. Доорх дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг орон нутгын иргэдээс санал болгож буй газарт хэрэгжүүлэх байдлаар сонгож боловсруулав. Дүйцүүлэн хамгааллын ажлыг хэрэгжүүлэх байршил, арга хэмжээг нарийвчлан тодорхойлохдоо компаний зүгээс орон нутг ийн засаг захиргааны байгууллагатай хэлэлцэж зөвлөлдөх хэрэгтэй. Дүйцүүлэн хамгааллын ажилд

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

шаардагдах зардлын хувьд жилд 3 сая.төг болсон бөгөөд дүйцүүлэн хамгааллын ажлыг тухайн жилдээ төлөвлөн оруулж байгаа боловч ашиглалт олборлолтын ажлыг 6-сард эхлүүлхээр төлөвлөж байна.

БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох; Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын судалгааг хийж суулгахад тохиромжтой мод, бут, сөөгийг тодорхойлох төлөвлөгөө гаргах	Сонгож авсан талбайд	1.5	1.5	2024	БОННУ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага
2		Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын шаардлагатай хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийх	1.5 га	1.5	1.5	2024	
3		Биологийн нөхөн сэргээлт хийх, мод бут суулгах	Сонгож авсан талбайд	Удирдлага зохион байгуулалтын зардал		2024	
4		Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд мониторинг хийж, усалж арчлах				2024 оноос эхлэн	
5	Нийгмийн салбаруудаас зохион байгуулагдаж байгаа ажилд хандив тусламж үзүүлж дэмжин ажиллана	Нийгмийн салбаруудаас зохион байгуулагдаж байгаа ажилд хандив тусламж үзүүлж дэмжин ажиллана	Сумын ЗД-ын Тамгын газартай Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад	Төсвийн тухай хуулийн 25.3-т заасан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна”.		2023	Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээг Төсвийн тухай хуулийн 25.3- т заасан хэмжээгээр тогтоон ажиллана.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6	Баяжуулах үйлдвэрийн кемпийн ойр орчим, уурхайн хэсэгчилсэн газарт ойжуулалт эхлүүлэн ажиллана	Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын судалгааг хийж суулгахад тохиромжтой мод, бут, сөөгийг тодорхойлоно	компанитай хамтран ажиллах.				"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллана.
Нийт зардал				3.000.000			

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд болон цаашид ойролцоох аж ахуйн нэгж, иргэдэд нүүлгэн шилжүүлэх шаардлага өгөөгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ өнөөгийн төслийн хүчин чадал, техник эдийн засгийн үндэслэлийн үед гарахгүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Чулуут интернэшнл” ХХК нь дотоод аюулгүй ажиллагаандаа ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллана. Уурхайн үйл ажиллагаанд гэрээт байгууллагатай хамтран ажиллах шаардлага гарсан тохиолдолд энэ талын сургалт, аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу баримтлах зарчмыг баримтлах нь зүйтэй. Төсөл хэрэгжүүлэгч уурхайн гэнэтийн ослын эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон ХАБЭАн арга хэмжээг хэрэгжүүлэхэд магадлашгүй зардлыг санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан шаардлагатай.

ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа
Газар хөдлөл	Стандартын дагуу баригдсан улсын комисст шалгуулан хүлээн авсан барилга, байгууламжийг ашиглах		Төсөл хэрэгжихийн өмнө
Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах, цахилгаан дамжуулах хийцлэлтэй материалтай болон цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх		Үйл ажиллагаа эхлэхийн өмнө хийсэн байна.

**ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР
ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Аадар бороо	Уурхай болон барилга байгууламжуудыг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох		Үйл ажиллагааны туршид
Шороон шуурга	Уурхайд онцгой байдал, осол эрсдлийн журам боловсруулан мөрдөж ажиллах		
Халдварт өвчин, цар тахал.	Ахуйн ариун цэвэр сахих Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх, хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)		
Авто машины тос, тосолгооны материал, гидрийн шингэн, тосол асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.		

ХИМИЙН БОДИС ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэсэлгээний бодис материалын хэмжээ, үзүүлэлтүүд: Төслийн үйл ажиллагаанд жилд 1-2 удаа хөрс, чулуулгийн сийрэгжүүлэлтэнд тэсэлгээний ажил хийгдэх ба энэ нь тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналт дор хийгдэнэ. Тэсэлгээг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллага гүйцэтгэх ба тэсрэх бодис нь хэрэв Анфо бол 94% аммоний нитрат, 6% дизель түлш агуулсан химийн бодис байдаг бол гадаргын устай үед эмульсийн тэсрэх бодисыг ашиглах бол энэ нь доторх шатах шингэн нь аммиакийн шүүний усанд ханасан уусмалын жижиг хэсгүүдийг нимгэн үе үүсгэн бүрхсэн уусмалын ба тосон фазын нэгдлээс тогтдог (Зураг 6.1). Усанд тэсвэртэй тэсрэх бодисын шинэ нэр төрөл, чиглэл нь эмульсийн тэсрэх бодис юм. Энэ нь эмульс доторх шатах шингэн нь аммиакийн шүүний усанд ханасан уусмалын жижиг хэсгүүдийг нимгэн үе үүсгэн бүрхсэн уусмалын ба тосон фазын нэгдэл юм. Энэ тэсрэх бодис нь усанд тэсвэртэй физик тогтонги чанар сайтай, харьцангуй хямд үнэтэй, бэлтгэхэд аюул осолгүй, ямар ч нөхцөлд хэрэглэх боломжтой, тэсрэлтийн шинж чанарын үзүүлэлт өндөр зэрэг давуу сайн талуудтай. Эмульсийн тэсрэх бодисын үндсэн найрлага нь аммиакийн шүүний эмульсийн уусмал, шатах шингэний нэгдэл юм.

“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн ерөнхий зүйлийн 18-д зааснаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг агуулахад тохирох ангиллын дагуу тус тусад нь хадгална. Тэсэлгээний аюулгүй ажиллагаа: Хэрэв тэсэлгээний тооцоогоор чичиргээний аюултай үйлчлэх R_r радиусын хэмжээ нь бодит зайн хэмжээнээс давж байвал барилга байгууламжид чичиргээ доргио аюултай нөлөө үзүүлнэ. Иймээс аюулгүйн зайн талаас нь бодож нэг удаагийн тэсэлгээнд хамрагдах тэсрэх бодисын хэмжээг хязгаарлах арга хэмжээ авна. Аюултай бүсүүдийн хилийг тогтоож, тусгай тэмдэг байрлуулах ба тэсэлгээний өмнө харуул хамгаалалт гаргана. Тэсрэх материалыг зөөх, байрлуулах, цооногуудыг цэнэглэх холболтууд хийх зэрэг тэсэлгээний бэлтгэл ажиллагааг дүрэм журмын заалтуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Тэсэлгээнээс өмнө аюултай бүсэд буй тоног төхөөрөмжүүдийг холдуулж аюулгүй бүсэд гаргах цахилгааны шугамыг хүчдэлгүй болгох зэрэг аюулгүйн нөхцөл хангах ажиллагаануудыг хэрэгжүүлнэ. Тэсэлгээг хэвшиж тогтсон өдөр цагт явуулна.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ" ЖОНШТ ТОЛГОЙН" ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ" ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тэсэлгээний аюултай бүсээс хүмүүсийг гаргахын тулд анхааруулах дохио өгдөг. Уурхайнуудад ихэвчлэн дуут дохиог хэрэглэдэг. Зарим уурхайд бага цэнэг тэсэлж дохио өгч хэвшсэн байдаг. Тэсэлгээг удирдаж буй хүн бэлэн байдлыг хянаж дохио өгсний дараа тэсэлгээчин тэсэлгээг явуулна. Тэсэлгээний дараа тэсэлгээ явагдсан блокт үзлэг хийж гацаа (бааралт) үүссэн эсэхийг тогтооно. Тэсэлгээ хэвийн явагдсан бол дохио өгч тэсэлгээ дууссаныг мэдэгдэнэ. Хэрэв ямар нэгэн гацаа үүссэн байвал түүнийг устгах арга хэмжээ авна. Тэсэлгээ дууссан дохио өгөгдөөгүй тохиолдолд аюултай бүсэд орох, үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөхгүй. Их хэмжээний тэсрэх бодис хэрэглэсэн буюу эсвэл гүн уурхайн гүний хэсэгт тэсэлгээ хийсэн бол тэсэлгээний дараах агааржуулалт явагдсаны дараа тухайн бүсэд хүн ажиллаж болно. Тэсэлгээ бүрийг хэрэгжүүлсэн тухай баримт үйлдэнэ.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслөөс гарах хог хаягдлын төрлүүд ба хэмжээ: Хайлуур жоншны ордыг ашиглах энэхүү төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа хэдий БОМТ-ний хүрээнд хэрэгжих энэхүү төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэх байдлаар тооцлоо.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.төг /5жил/	Хугацаа ба давтамж
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Баяндэлгэр сумын холбогдох байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулах	2024	Дотоод төлөвлөлтөөр		Төв аймгийн ИНХ-ын 2019 оны 03-р сарын 25-ны өдрийн 37 тоот тогтоолын дагуу, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/87 дугаар тушаалын хавсралт “Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам”-ын дагуу
	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	120.0	600.0	
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, баяжуулах үйлдвэр оффис, тэсрэх материалын агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах		200.0*5 ш	1000.0	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх		Хэрэглээнээс гарснаар		
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх		Хэрэглээний хэмжээгээр		
	Хог хаягдлын хор үршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх				
Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Уурхайн хэмжээнд	10.0	12 сар*10.0*1 жил=72.0		
Нийт дүн /жилд/			1.800.000		

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЗАРДАЛ

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр төслийн чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам хугацаанд тогтоож мөрдөнө	Үйл ажиллагааны турш	-	Уурхайн дарга	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, Галын аюулгүй ажиллагааны дүрэм ISO 14001:2004 Байгаль Орчны Удирдлагын Тогтолцоо 2003 оны Засгийн газрын 28-р тогтоолоор баталсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийх журам”, БХБ-ын сайдын 2019 оны 34-р тушаалаар баталсан “Газрын төлөв байдал, захиалгат хянан баталгааны аргачилсан зааварын дагуу
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байуулах талаар 1 жилд 2 удаа сургапт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	6, 9-р саруудад	10.0*2 удаа*1 жил= 1.00	БО-ажилтан Уурхайн дарга	
БО мэргэжилтийг сургалтанд хамруулах	Жилд 1 удаа	250.0*1 жил=250.000	Компаний удирдлага БО-ны ажлтан	
Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	Жилд 1 удаа	-		
Гал унтраах хэрэгслээр уурхайг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Галын хор – 25кг-45.0₮	-		
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй харилцан тохиролцох	2 жилд 1 удаа	-	захирал	
Газрын төлөв байдал, чанарын үлсын хянан баталгаа хийлгэх	2024 онд	-		

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг сум, аймгийн БО-нд салбар нэгжид тайлагнан дүгнүүлж, БОАЖЯ-аар БОМТ батлуулж байна	Жил бүрийн 10-12 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		
Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог Уурхайн дотоод төлөвлөлтөөр идэвхижүүлэх, уулзалт зөвлөлгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд			
Нийт дүн				1.120.000

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ЗАРДАЛ

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
09 сар*	Сум орон нутгийн иргэд, ЗДТГ-т танилцуулах Компанийн захирал Төслийн үйл ажиллагаа, байгаль орчны Уурхайн дарга менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, нөхөн сэргээлтийн явц зэргийн орон нутгийн иргэдийн төлөөлөлд танилцуулж, бусад сонирхсон асуудлаар чөлөөт ярилцлага хийнэ.	Үйл ажиллагааны зардалд багтана	Компанийн захирал Уурхайн дарга БО-ны ажилтан
10 сарын 01*	Аймгийн БОГазарт жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлэн дүгнүүлэх		БО-ны ажилтан
12 сарын 01*	БОАЖЯ-нд жил бүрийн БОМТ хүргүүлэн батлуулах		

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР
АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 3.1 дүгээр зүйл, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуульд зааснаар төслийг хэрэгжүүлэх явцад төслөөс байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдалд тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) гэнэ. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр нь “Жонш толгойн” хайлуур жоншны орд ашиглах төсөл хэрэгжиж буй бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлтүүдийг эрт тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллага, нутгийн оршин суугчдад байгаль орчин, амьдрах орчны өөрчлөлтийн талаар бодит мэдээлэл өгөх үндсэн зорилготой. Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтийг хянаж, байгаль орчныг хамгаалах ажлын үр дүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөх зорилгоор орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх мөн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдалд өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ нь байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Уг хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжих газрын агаар, усны чанар, хөрс, амьтан, ургамлын асуудлыг онцлон анхааран авч үзсэн бөгөөд байгаль орчны бохирдол, өөрчлөлтийгхянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм, заавар арга зүйг баримтлах шаардлагатай.

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН НУТАГТ ХЭРЭГГИЖ БУЙ” ЖОНШТ ТОЛГОЙН” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ БОЛОН БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил координат	Хугацаа, давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, төг/жил	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ баримтлах стандарт
Усан орчин	Усан орчин рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл СО ₂ , хүчил НСО ₃ , кальци Са, хлор Сl, кали К, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл Ag, бор В, бари Ва, кадми Cd, кобальт Со, хром Сг, зэс Си, төмөр Ре, мөнгөн үс Нg, манган Мп, молебдин Мо, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Аl, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ	1. Уурхайгаас 2 км-ын зайд байрлах орон нутгийн худаг 47034I21.3II - 108015I16.8II 2. Ажилчдын хоолны газрын хойд талд 47039I48.70II - 108018I13.20II 3. Баяжуулах үйлдвэр дотор 47039I48.10II - 108018I04.70II 4. Бохирын худаг шинээр төлөвлөж байна	Жилд 2 удаа буюу 5 болон 9 саруудад мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө	Усны ерөнхий химийн шинжилгээ 41.800 төгрөг Усны 11 элемент хүнд металын шинжилгээ 38.500 төгрөг “Инженер геодези” ХХК Хими, бактериологи бүрэн, шинжилгээний үнэ 45.210 төгрөг “УСНЫ газар”	125.510 * 4 * 2 = 502,040 Жич: Бохирын худаг одоогоор байгуулагдааг үй тус зардлын тооцсонгүй. Байгуулсны дараа зардал нэмэгдэнэ.	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586:1998 Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага. MNS 3342:1982 Ундны үс. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS0900:2018 MNS (ISO) Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир үс. Ерөнхий шаардлага. MNS4943:2011
Нийт дүн				502.040 төг		

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

№	Ажлын нэр	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3.500.000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	
3	Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх зардал	3.000.000
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1.800.000
5	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1.120.000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	502.040
Нийт зардал		9.922.040 төг

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **9.922.040** төгрөг зарцуулахаар байна.